

“МОННООС”  
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 21-ны өдөр

Дугаар 02/25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам”-ын 2.2-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 29-ны өдрийн 14,00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороолол, Билэгт зам ХХК-ийн 4 давхар байр, 1-р давхарын хурлын танхимд хуралдуулахаар товлоусугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайлан

2.2 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагаанд, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах

2.3 Компанийн хөрөнгөнд Хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас гаргасан үнэлгээний тайланг танилцуулах

2.4 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох

2.5 Компанийн 2025 оны Удирдлагын зардлын төсвийг хэлэлцэж батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4-р сарын 14-ний өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д мэдэгдэх өдрийг 2025 оны 3-р сарын 26-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2025 оны 3-р сарын 26 болон 4-р сарын 09-ны өдрүүд байхаар тогтоосугай.

5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2025 оны 3-р сарын 26-ны өдрөөс Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, мөн өдрөөс хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх, 2025 оны 3-р сарын 26-ны дотор болон 4-р сарын 09-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисс /Б.Алтангэрэл/-т даалгасугай.

6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар

- 6.2 Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан  
6.3 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолууд  
6.4 Хурлын санал хураах хуудас  
6.5 ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга  
6.6 Компанийн 2025 оны Удирдлагын зардлын төсөв

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04-р сарын 29-ны өдрийн 14.00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Б.Алтангэрэлийг, хурлын тооллогын комиссын даргаар Д.Даваасүрэнг томилсугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах комисс /Б.Алтангэрэл/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮН



П.ОЮУНБАЯР

С.АЛИМАА

С.МӨНХЖАРГАЛ

П.ОЮУНБАЯР

Б.МЭДРЭЭ

И.СЭР-ОД

Ж.БОЛДБААТАР